



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 1/53

Номгон

Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын  
тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.7, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох "Гурван тахилгат оргил" ХХК-ийн талбайн хэмжээ, байршил, солбилцол, тусгай зөвшөөрлийн хугацааг хавсралт ёсоор баталсугай.


2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газрын дарга /Н.Бямбадорж/, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Ганзориг/, Өлзийт сумын Засаг дарга /Т.Эрдэнэбат/ нарт тус тус даалгасугай.

3.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон талбайг газрын кадастрын цахим системд бүртгэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Д.Алтангэрэл/-д үүрэг болгосугай.

4.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлүүлж, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Хишигбаатар/-т даалгасугай.


5.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уул уурхай, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч /Г.Энхбаяр/-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны  
өдрийн А/53 дугаар захирамжийн хавсралт



ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТАЛБАЙ, СОЛБИЛЦОЛ, ХУГАЦАА

№	Аж ахуйн нэгжийн нэр	Сумын нэр	Талбайн нэр	Талбайн хэмжээ /га/	Олгосон огноо	Дуусах огноо	Солбилцол	
							Уртраг	Өргөрөг
1	Гурван тахилгат оргил ХХК	Өлзийт	Өвдгийн худаг	25.34 га	2021.01.20	2036.01.20	100 46 51.88	46 6 50.79
							100 46 35.19	46 6 50.79
							100 46 35.19	46 7 13.71
							100 46 51.88	46 7 13.71